



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 02 өдөр

Дугаар Б/01.

Чингис хот

Ж.Ганбаярыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 57 дугаар зүйлийн 57.1, 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 274 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” 277 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа, хүний эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй Жамцын Ганбаярыг 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Л.Бат-Октябрь

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

Т.Бямбадулам

Архив, бичиг хэргийн эрхлэгч


Т.Баяртуяа

Нярав

3. Ж.Ганбаярын цалинг ТЗ-6-5 шатлалаар тогтоон үндсэн цалин 790162 /долоон зуун ерэн мянга нэг зуун жаран хоёр/ төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 20, зэрэг дэвийн нэмэгдлийг 24, хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны нарийн бичгийн даргын ажлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 10 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч /Г.Ариунхүү/-д зөвшөөрсүгэй.

4. Эрх зүйн сургалт, сурталчилгаа, хүний эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ж.Ганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР